**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 02 өдөр Дугаар А/22 Өлгий

Олон Улсын Сувилагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрөөс Эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/201 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оны 05 дугаар сарын 12-ны Олон улсын сувилагчдын өдрийг “Сувилагчийн бие даасан байдал–Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулъя” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Энэхүү уриан дор зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, Эрүүл мэндийн салбарын хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар, үйл ажиллагааны удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү уриан дор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж, нийтэд мэдээлэл хүргэх, шинэлэг үйл ажиллагаа зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг харьяа бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг нэгтгэн Эрүүл Мэндийн яаманд явуулахыг Эрүүл мэндийн газрын сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн /С.Сунхар/ -т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.САКЕН

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 05 сарын 02 өдрийн А/21 тоот
тушаалын хоёр дугаар хавсралт

**“СУВИЛАГЧИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ – СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛЪЯ” УРИАН ДОР ОУСӨ-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Зорилго:** Сувилагч, эх баригчийн ёс зүй, мэргэжлийн үнэ цэнэ, бие даасан байдал, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах.

| № | Хийх үйл ажиллагаа | Хугацаа | Зохион байгуулалт | Хариуцах байгууллага, эзэн. |
|---|---|---|---|---|
| 1 | Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан “Сувилагчийн бие даасан байдал – Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулъя” Сувилагчийн нэг өдөр аяныг зохион байгуулах. | 2022.05.09. | Тухайн байгууллага, тасаг нэгж дотор | ЭМГ, ЭТХэлтэс, ажлын хэсэг. |
| 2 | Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд сувилагч, эх баригч мэргэжлийн сурталчлах, олон нийтийн мэдээлэл суваг, ТВ нэвтрүүлэг, ярилцлага хийх | 2022.05.01-аас 2022.05.12-ны хүртэл | ТВ нэвтрүүлэг хийх, олон нийтэд хандсан кондент сошиалд мэргэжлээ сурталчлах | НЭ, Сум, Өрх, Тосгоны ЭМТ, Сансар эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгүүд |
| 3 | Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах шинэ технологи, сайн туршлага нэвтрүүлэх, чанарын өдөрлөг зохион байгуулах | 2022.05.01-аас 2022.10.01-ны хүртэл | Тасаг нэгжийн онцлогт тохируулан сувилахуйн чанарын өдөрлөг | НЭ, Сум, Өрх, Тосгоны ЭМТ, Сансар эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгүүд |
| 4 | Сувилахуйн алба, багуудыг чадавхжуулах, туршлага судлуулах ажлыг зохион байгуулах. | 2022.05.01-аас 2022.10.01-ны хүртэл | Үйл ажиллагааны тайлан | НЭ, Сум, Өрх, Тосгоны ЭМТөв |
| 5 | Сувилахуйн тусламж, үйлчилгээтэй холбоотой үзүүлэх сургууль, сувилахуйн эмнэлзүйн хэлэлцүүлэг зохион байгуулах | 2022.05.22-25 хооронд | Үйл ажиллагааны тайлан | Нэгдсэн эмнэлэг |
| 6 | “Сувилагчийн бие даасан байдал – Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулъя” сэдвийн хүрээнд эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах | 2022.05.11 | Хөтөлбөрийн дагуу | ЭМГ, НЭ, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7 | Сувилагчдын ажиллах орчин, нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулах, үр дүнг тооцох | 2022.05.01-аас 2022.10.01-ны хүртэл | Үйл ажиллагааг шат дараалан төлөвлөн хэрэгжүүлэх | НЭ, Сум, Өрх, Тосгоны ЭМТ, Сансар эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгүүд |
| 8 | Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах | 2022.05.01-аас 2022.10.01-ны хүртэл | Үйл ажиллагааг шат дараалан төлөвлөн хэрэгжүүлэх | ЭМГ, НЭ, |
| | “Сувилагчийн бие даасан байдал – Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулъя, сувилагчийн ёс зүй” болзолт уралдаан | 2022.05.01-аас 2022.10.01-ны хүртэл | Батлагдсан удирдамж, үйл ажиллагааны тайлан, үр дүнг тооцсон байдал | ЭМГ |
| 9 | Зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг хугацаанд нь ЭМГ-т хүргүүлэх | 2022.10.15-ны хүртэл | Үйл ажиллагааны тайлан ирүүлэх, үр дүнг тооцох | Харъяа байгууллагууд |
| 10 | ОУСӨ-ийг тохиолдуулан зохион байгуулсан арга хэмжээг дүгнэж, тайланг нэгтгэн ЭМЯ, ЭМЯ-ны дэргэдэх сувилагчийн салбар зөвлөлд хугацаанд нь явуулах | 2022.10.30 | Үйл ажиллагааны тайлан | Эрүүл мэндийн газар, ЭТХэлтэс, ажлын хэсэг |

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 05 сарын 02 өдрийн А/22 тоот
тушаалын ........................ хавсралт

# *“СУВИЛАГЧИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ – СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛЪЯ, СУВИЛАГЧИЙН ЁС ЗҮЙ” БОЛЗОЛТ УРАЛДААНЫ УДИРДАМЖ*

***Зорилго:***

Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулж, сувилагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх зорилготой.

***Зорилт:***

1. Үйлчлүүлэгчдэд үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний өнөөгийн байдалд үнэлгээ өгөх.
2. Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааг төлөвлөх.
3. Сувилагчийн харилцаа хандлага, ёс зүйг үнэлэх үнэлгээний хуудас боловсруулан хэрэгжүүлэх.
4. Хэвтэн эмчлүүлэгч болон үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэх.

***Хугацаа:***

2022 оны 05- сарын 01-аас 07-р сарын 01-ны хүртэл / 2 сар /

***Хамрах хүрээ:***

Аймгийн нэгдсэн эмнэлэг, сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төв

***Хаана зохион байгуулах:***

Байгууллагууд өөрсдийн эрүүл мэндийн байгууллага дээр, үйлчлүүлэгчдэд зориулж үйл ажиллагаа зохион байгуулна.

***Шалгаруулалт:***

1. Зохион байгуулсан үйл ажиллагааг үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаагаар дүгнэх. Тэргүүний үйл ажиллагаа зохион байгуулсан байгууллага, хамт олон, хувь хүнийг шагнан урамшуулна.
2. Ажлын хэсэг бүртгэгдсэн гомдолын дагуу ажиллах, байгууллагуудаас ирүүлсэн тайлан болон газар дээр нь очиж ажиллаж дүгнэнэ